



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/41

Модот

Мал, амьтны сэг зэм зэм устгал орчны
халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион
байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг зэмээс хүн, малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай

2. Мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч: С.Энхбаяр

Гишүүд: У.Гантулга

Б.Чулуунцэцэг

Д.Мягмарсүрэн

О.Тунгалагмөрөн

П.Ганчимэг

Ж.Тодбилэг

Б.Уранчимэг

Б.Хатансайхан

С.Баясгалан

Э.Батжаргал

Э.Энхтүвшин

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч

- Хужхан багийн Засаг дарга

- Нугаар багийн Үасаг дарга

- Согоот багийн Засаг дарга

- Баянмод багийн Засаг дарга

- Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч

- Байгаль хамгаалагч

- "Дэрст хайрхан" МЭҮН

- "Дэрст хайрхан" МЭҮН

- "Цэнхэр бэлчир" МЭҮН

- "Үржих баян мандал" МЭҮН

- "Цэнхэрмандал хөгжил" ОНӨААТҮГазрын дарга

2. Мал, амьтны хашаа байр, үхсэн малын сэг зэм усгал, худаг уст цэгийг заавар журмын дагуу халдваргүйтгэх ажлыг хийж гүйцэтгэхийг малын эмч нарт даалгасугай

3. Үхсэн малын сэг зэм усгахад шаардагдах халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас болон бусад хөрөнгийг сумын орон нутгийн хөгжлийн сангын хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй

4. Мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, удирдлагаар хангаж, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, нэгдсэн тайлан мэдээг холбогдох газар хэлтэст хүргэж ажиллахыг МЭУБайцаагч (П.Ганчимэг), БОХУБайцаагч (С.Энхбаяр), Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (У.Ичинхорлоо) нарт тус тус үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

